# "ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ" ОНӨААТҮГ-ЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ДҮГНЭЛТ

Нэг: **Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго**:нийслэлийн "ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ" ОНӨААТҮГ-ын 2025 оны хагас жилийн үйл ажиллагаа, чиг үүргийн хүрээнд хэрэгжиж буй төрийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүнг үнэлж, сайжруулах шаардлага бүхий ажлыг тодорхойлж, хариуцлагыг дээшлүүлэн, удирдлагыг мэдээлэл зөвлөмжөөр хангаж, байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

Хоёр: **Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үндэслэл, арга зүй**:байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ монгол улсын засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.3-ыг үндэслэн 2025 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн дүгнэж үнэлгээ хийсэн.

Гурав: **Хяналт-шинжилгээ, үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний арга хэмжээ | Хэрэгжилт | Хэрэгжилт үнэлгээ | Хяналт шинжилгээний үнэлгээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Стратеги төлөвлөгөөний зорилго-1:(МУХТ-2025-7.1.2) НХТЖҮЧ-9.21.3 НХТ-1.4.2.Нийтийн тээвэр, логистик | 1.Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг 30 хувиар нэмэгдүүлнэ.<br>1.1.Нийтийн тээврийн чиглэл, тээврийн хэрэгслийн хуваарилалтыг оновчтой болгох ажлын хүрээнд Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газраас баталсан замналын дагуу ажил үйлчилгээг зохион байгуулж ажиллах<br>1.2.Нийтийн тээврийн хэрэгслээр тэргэнцэртэй иргэн зорчих нөхцөлийг бүрдүүлэх<br>1.3."Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын автобус паркийн барилгын II ээлжийн барилгыг үргэлжлүүлж барьж дуусгах | 1.1.Нийтийн тээврийн бодлогын газраас батлагдсан цаг, график замналын дагуу<br>• Маршрут<br>• Үйлчилгээ<br>• Хот доторх<br>• Хот орчим<br>• Дунд овор<br>• Сургуулийн үйлчилгээ<br>гэсэн чиглэлүүдэд үйлчилгээ үзүүлж байна. 2025 оны 06 дугаар сарын байдлаар нийтийн тээврийн хот доторх 15, хот орчимд 6, сургуулийн 8, нийт 21 чиглэлд ажлын өдөр 134, сургуулийн 8, амралтын өдөр 109 гаралт тус тус гаргаж үйлчилгээ үзүүлж байна. Шаардлагатай тохиолдолд чиглэл бүрт маршрут, эргэлтийн хугацааг өөрчлөн хамтран ажиллаж байна.<br>1.2.Нийтийн тээврийн бодлогын газрын бүртгэлийн санд 159 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагийн том оврын 142 | 93% | 93% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | тээврийн хэрэгсэл нь тэргэнцэртэй иргэн зорчих нөхцөл бүрдсэн байна.<br>1.3.II ээлжийн барилгын ажлыг гүйцэтгэх 3 байгууллагын гэрээг цуцалсан бөгөөд НХОГ-аас ажлын тоо хэмжээг салгаж дахин төсөв гаргах ажил хийгдэж байна. | | |
| 2 | Стратеги төлөвлөгөөний зорилго-2:НХТЖҮЧ-5.3.2 НХТ-5.1.Цахим засаглал:Иргэдийн оролцоог хангасан, авилгаас ангид, үр нөлөөтэй, цахимжсан, хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалыг төлөвшүүлнэ. | 2.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас цахимаар үзүүлдэг үйлчилгээний тоог 30 хувиар нэмэгдүүлнэ.<br>2.1.Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний стандартыг мөрдөж, үйлчилгээний ёс зүйн хэм хэмжээ, хууль тогтоомж, дүрэм журмыг баримтлан ажиллах. | 2.1.Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний стандартыг мөрдөж, үйлчилгээний ёс зүйг эрхэмлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар 25 санал гомдол ирснийг шийдвэрлэж, хяналт тавин ажиллаж байна. | 100% | 100% |
| 3 | Стратеги төлөвлөгөөний зорилго-3:НХТЖҮЧ-5.1.2 НХТ-5.2.Орон нутгийн засаглалын бие даасан байдал: Төрийн үйлчилгээний ил тод байдал нэмэгдэнэ. | 3."Олон улсын түвшинд нийцсэн үндэсний стандартыг"-ыг нэвтрүүлнэ<br>3.1.MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. | 3.1.Чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх, бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг Газрын даргын 2025 оны А/39 дүгээр тушаалаар томилон ажиллуулж байна. | 50% | 50% |
| | Стратеги төлөвлөгөөний зорилго-4:НХТЖҮЧ-5.1.2 НХТ-5.2.Орон | 4.Авлигаас ангид, хариуцлагатай, тогтвортой засаглалыг төлөвшүүлнэ.<br>4.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн | 4.1.Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөг гаргаж батлуулсан. "Ёс зүйн дүрэм"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2025 оны хагас жилийн байдлаар "Ёс зүйн хороо"-нд 1 ажилтнаас гомдол ирсэний дагуу ёс зүйн хороо хуралдаж холбогдох шийдвэрийг гаргаад байна. | 81,25% | 81,25% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 4 | нутгийн засаглалын бие даасан байдал:Төрийн үйлчилгээний ил тод байдал нэмэгдэнэ. | хүрээнд байгууллагын "Ёс зүйн дүрэм"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах<br>4.1.1.Төрийн албан хаагчид ёс зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, удирдамж, заавраар хангах, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөл бүхий орчныг бүрдүүлж, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.<br>4.1.2.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэвшүүлэх, баримтлан ажиллахад чиглэсэн үйл ажиллагаар байгууллагын удирдлага манлайлан, Ёс зүйн дэд хорооны дэмжлэгтэйгээр тогтмол хэрэгжүүлнэ.<br>4.1.3.Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангана.<br>4.2.Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө" батлуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах<br>4.2.1.Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулна.<br>4.2.2.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030 он)-г хэрэгжүүлж, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.<br>4.3.Арга хэмжээ-2:Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, албан | 4.1.1.Төрийн албан хаагчид ёс зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, удирдамж, заавраар хангах, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөл бүхий орчныг бүрдүүлэн ажиллаж байна.<br>4.1.2.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, баримтлан ажиллахад чиглэсэн үйл ажиллагаар хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>4.1.3.Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэн, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангах үүднээс "Манд.mn" сайттай хамтран ажиллаж байна.<br>4.2. Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/25 дугаар тушаалаар "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө" баталж, 5 зорилгын хүрээнд 22 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж, авлига, ашиг хонжоо, давуу байдлаас ангид байх, олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулж, "Авлигын эсрэг төлөвлөгөө"-ний биелэлтийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.<br>4.2.1.Авлигатай тэмцэх газартай хамтран Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах талаар https://iaac.mn/training цахим хуудсаар хамтран ажиллах хүсэлт хүргүүлсэн.<br>4.2.2.Улсын Их хурлын 2024 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээг Үйлдвэрийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган авч хэрэгжүүлэн ажиллаж байна: 2.1.3."Төрийн албаны журам, стандарт, менежментийг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх замаар төрийн албан хаагчийн ёс зүйг төлөвшүүлнэ" гэхийг гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.2. "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэвшүүлэх, баримтлан ажиллахад чиглэсэн үйл ажиллагаар байгууллагын удирдлага манлайлан, Ёс зүйн дэд хорооны дэмжлэгтэйгээр тогтмол хэрэгжүүлнэ." хэмээн тусгаж,<br>2.1.6."Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой төрд учруулсан хохирлын бүртгэл, хяналтын нэгдсэн системийг бий болгож, хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих тогтолцоог бүрдүүлнэ" гэхийг 13.31."Хэлтэс, нэгж, ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | хаагчийн хөрөнгө оруулгын мэдүүлгийг үнэн зөв гаргаж, хуулийн хугацаанд холбогдох дээд байгууллагад хүргүүлж ажиллах | тайланд хяналт тавьж, байгууллагын гүйцэтгэлийн тайланг дүгнэж ажиллах" хэмээн ажилтны төлөвлөгөөнд тусгаж, 2.2."Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянах үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгоно" гэснийг 4.3. "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, албан хаагчийн хөрөнгө оруулгын мэдүүлгийг үнэн зөв гаргаж хуулийн хугацаанд холбогдох дээд байгууллагад хүргүүлэн ажиллах" хэмээж,<br>2.5.4."Иргэн аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэлийг хянах нэгдсэн цахим системийг нэвтрүүлж хоёр жил тутамд хяналт шинжилгээ хийнэ" гэснийг 12.1 "Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, кибер аюулгүй байдлыг хангаж хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулна" гэж, мөн үйлдвэрийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.2.2-д "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030 он)-г хэрэгжүүлж, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ" хэмээн тусган ажиллаж байна.<br>4.3.Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасны дагуу Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсийн даргын ХАСХОМ-ын мэдүүлгийг 2025 оны 02 дугаар сарын14-ний өдөр, Санхүү бүртгэлийн хэлтсийн даргын ХАСХОМ-ын мэдүүлгийг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр, Техник, технологийн хэлтсийн даргын ХАСХОМ-ыг 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр, Дотоод хяналт шалгалтын хэлтсийн даргын ХАСХОМ-ын мэдүүлгийг 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр, шинээр томилогдсон Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсийн даргын ХАСУМ-ын мэдүүлгийг 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хянуулж, мөн оны 03 дугаар сарын 17-ны өдөр ХАСХОМ-ын мэдүүлгийг мэдүүлж, Дотоод хяналт, шалгалтын хэлтсийн даргын ХАСУМ-ын мэдүүлгийг 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хянуулж, мөн оны 03 дугаар сарын 18-ны өдөр ХАСХОМ-ын мэдүүлгийг мэдүүлж, Санхүү, бүртгэлийн хэлтсийн ахлах нягтлан бодогчийн ХАСХОМ-ын мэдүүлгийг 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр тус тус мэдүүлж, хуулийн хугацаанд мэдүүлсэн. | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 5 | Стратеги төлөвлөгөөний зорилго-5:НЗДҮАХ-4.2.3, ХАХТ 4.2.3.1, НХТЖҮЧ 4.6.1 НХТ-5.2.Орон нутгийн засаглалын бие даасан байдал:Төрийн үйлчилгээний ил тод байдал нэмэгдэнэ. | 5.Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын материаллаг орчныг сайжруулна.<br>5.1.Инженер техникийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтын тогтолцоог бэхжүүлж, ур чадвар идэвх санаачилгыг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах<br>5.2.Байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөө боловсруулах, шинэчлэх, материаллаг орчныг сайжруулах, цахим сургалтын системийг хөгжүүлэх, үр дүнг тооцож ажиллах<br>5.3.Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд холбогдох чиг үүргийн нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага судлах, ажлын уялдаа холбоог хангах | 5.1.Байгууллагын инженер, техникийн ажилтнуудад чиглүүлэх сургалтыг 2<br>удаа зохион байгуулсан. Мөн БНХАУ-ын Юутонг автобусны үйлдвэрт Засварын инженер 1,<br>Урсгал засварын засварчин 2 нийт 3 ажилтанг борлуулалтын дараах засвар үйлчилгээний чадавхийг сайжруулах, мэргэшүүлэх сургалтад 06 дугаар сарын 23-ны өдрөөс 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд хамруулахаар холбогдох баримт бичгийг бүрдүүлээд байна.<br>5.2.2025 оны сургалтын төлөвлөгөө батлуулж, сургалтын материаллаг орчныг сайжруулж, үр дүнг тооцон ажиллаж байна. Нийт 23 төрлийн сургалт зохион байгуулахаар төлөвлөснөөс 12 төрлийн сэдвээр сургалт зохион байгууллаа.<br>5.3.Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх хамтран ажиллах, туршлага судлах ажлын хүрээнд "Автобус-2" ОНӨААТҮГ, "Автобус-4 ОНӨААТҮГ", "Автобус-5" ОНӨААТҮГ-тай хамтран ажиллаж байна. | 84% | 84% |
| 6 | Стратеги төлөвлөгөөний зорилго-6:НХТЖҮЧ 5.3.2.5, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоол НХТ-5.2.Орон нутгийн засаглалын бие даасан байдал:Төрийн үйлчилгээний ил тод байдал нэмэгдэнэ. | 6.Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулна.<br>6.1.Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах<br>6.2.Архивын цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийх<br>6.3.Байгууллагын албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөх ажлыг зохион байгуулах | 6.1.Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр байгууллагын өргөдөл, гомдол, албан бичгийг "erp ulaanbaatar.mn" системээр хуульд заасан хугацаанд хүлээн авч, шийдвэрлэж, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллаж байна.<br>6.2.Архивын 2024 оны цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг хийж дуусгаад байна.<br>6.3.Байгууллагын албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн хөтлөн явуулах ажлыг эхлүүлээд байна. | 81,6% | 81,6% |
| 7 | Стратеги төлөвлөгөөний зорилго-7:НХТЖҮЧ | 7.Хотын хөгжлийн индекс тооцох үзүүлэлтийн тоог нэмэгдүүлнэ. | 7.1.Тайлант хугацаанд шилэн дансны https://info.shilendans.gov.mn вэб хуудсанд нийт 19 мэдээлэл оруулахаас хугацаанд нь 19 мэдээлэл, хугацаа нь болоогүй | 51,11% | 51,11% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | 5.1.1<br>НХТ-5.3.Ил тод байдал, хяналт:Нийслэл дэх төрийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, хяналт шалгалтын ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ. | 7.1.Шилэн дансны хууль тогтоомжийн хүрээнд санхүүгийн ил тод байдлыг хангаж сар бүр заасан хугацаанд байгууллагын холбогдох мэдээллийг шилэн дансанд байршуулах<br>7.2.Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг боловсруулах, тайлагнах, тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ. | 12, хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй байна.<br>7.2.Хариуцсан чиг үүргийн хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээнд үйлчилгээ үзүүлж буй нийтийн тээврийн хэрэгсэл, нийт ажилтан, албан хаагчдын мэдээ, мэдээллийг холбогдох программд оруулан ажиллаж байна. | | |
| | | 8.Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжсэн байна.<br>8.1.Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан ажилчдын ажлын хувцсыг дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнээс худалдаж авах | 8.1.Зуны болон өвлийн ажлын хувцсыг дотоодын үйлдвэрлэгчдээс хуульд нийцүүлэн сонгон шалгаруулалтаар шалгаруулж гэрээ хийхээр төлөвлөснөөс 685 ширхэг зуны ажлын хувцас худалдан авах ажиллагааг хуульд нийцүүлэн зохион байгуулж зарлаад байна. 6 дугаар сард багтаан сонгон шалгаруулж, гэрээг хийхээр төлөвлөж байна. Өвлийн ажлын хувцасны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг 3 дугаар улиралд зохион байгуулна. | | |
| | | 9.Мэргэшсэн, чадварлаг, иргэндээ үйлчилдэг, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.<br>9.1.Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах | 9.1.Газрын даргын 2025 оны А/36 дугаар тушаалаар "Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах" ажлын хэсэг томилогдон ажиллаж байна. | | |
| | | 10.Иргэдийн эрэлт, хэрэгцээнд суурилсан үйлчилгээний чанар, хүртээмж, найдвартай байдлыг хангах замаар хувийн авто машины хэрэгцээг багасгаж, нийтийн тээврээр зорчих зорчилтыг нэмэгдүүлнэ.<br>10.1.Нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээний чиглэл, сүлжээ, эгнээг оновчтой төлөвлөх, нийтийн тээвэр, зорчих зогсоолыг хөгжүүлэн хүртээмжийг нэмэгдүүлэхэд холбогдох дээд байгууллагад санал өгөх<br>10.2.Нийтийн тээврийн хэрэгслийн дундын болон эцсийн зогсоолын чанар, аюулгүй байдал, хүртээмжийг | 10.1. Хот орчмын чиглэлүүдийн зогсоолууд буудлын карма байхгүй, координат зөрчиж унщдаг чиглэлүүдийг судалж Нийтийн тээврийн бодлогын газрын тээврийн бодлого, судалгааны хэлтсийн зогсоол төлөвлөлт, сүлжээний инженертэй хамтран шугам замд 2 удаа судалгаа хийж саналаа хүргүүлэв.<br>10.2.Нийт чиглэлүүдийн эцсийн зогсоолыг судалж шаардлагатай чиглэлүүдийн эцэс болон ОО асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийтийн тээврийн бодлогын газарт санал хүргүүлэв. | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлэх болон удирдлага, хяналтыг дэвшилтэт техник технологи ашиглан сайжруулж салбарын чадавхыг бэхжүүлэхэд санал, санаачилга гаргаж ажиллах | | | |
| | | 11.Иргэдийн оролцоог хангасан, авлигаас ангид, ил тод, үр нөлөөтэй, цахимжсан, хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалыг төлөвшүүлнэ.<br>11.1.Хариуцсан чиг үүргийн хүрээнд чиг үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлнэ.<br>11.2.Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. | 11.1.Газрын даргын 2025 оны А/26 дугаар тушаалаар "Байгууллагын дотоод үнэлгээ зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай" тушаал гарч дотоод үнэлгээг зохион байгуулсан.<br>11.2."ICT GROUP" ХХК-тай хамтран Golden dragon 99, Yutong 30 автобусанд онлайн камерын төхөөрөмж бүрэн суурилуулсан ба хяналт, мониторингийн тогтолцоог бүрэн ажиллуулж хяналт, шалгалтыг өдөр бүр тогтмол хэрэгжүүлж ажиллаж байна. Golden dragon маркийн 1, County маркийн 17 автобусанд<br>онлайн камер суурилуулах хүсэлтийг "ICT GROUP" ХХК-д албан бичгээр хүргүүлж ажилласан. Суурилуулах ажил хүлээгдэж байна. | | |
| | | 12.Иргэдийн оролцоог хангасан, авлигаас ангид, ил тод, үр нөлөөтэй, цахимжсан, хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалыг төлөвшүүлнэ.<br>12.1.Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, кибер аюулгүй байдлыг хангаж хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулна. | 12.1.Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, аюулгүй байдлыг хангаж, хариуцлагын тогтолцоог сайжруулан ажиллаж байна. | | |
| 8 | Зорилго<br>13.Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилго | 13.1.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах<br>13.2.Нийслэлээс олгох машин цагийн зардлаас элэгдлийн зардлыг "Нийтийн тээврийг хөгжүүлэх сан"-д төвлөрүүлэх,<br>13.3.2025 онд Нийслэлийн төсөвт 2024 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас ногдол ашгийг төвлөрүүлэх<br>13.4.Ажилтан, албан хаагчдын цалин хөлсийг нийслэлээс баримталж байгаа бодлого, машин цагийн тарифт нийцүүлэн нэмэгдүүлэх боломжийг | 13.1.2025 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтын төслийг боловсруулан УЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн 2025 оны нийт орлогыг 50,126,389.10 мянган төгрөг, нийт зардлыг 53,258,834.54 мянган төгрөг, алдагдлыг 4,287,962.12 мянган төгрөг, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал 1.06 төгрөг, байхаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажилласан. Нягтлан бодох бүртгэлийн<br>тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын тушаалаар батлагдсан анхан шатны баримт бүрдүүлэх заавар, бусад санхүү бүртгэлийн холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт шаардлагад нийцүүлэн анхан шатны баримтыг хөтлөн өдөр тутмын хөтлөлтийг хийж ажилласан.<br>13.2.Нийслэлээс олгох машин цагийн зардлаас элэгдлийн | 82,41% | 82,41% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | судлах, санал хүргүүлэх;<br>13.5.Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2025 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэх<br>13.6.Байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах<br>13.7.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах<br>13.8.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах<br>13.9.Хууль тогтоомж, стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах<br>13.10.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллахдаа холбогдох хууль, журамд нийцүүлэн, үнэн зөв, бодитой тайлагнаж, мэргэжлийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулан, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэж, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүх үе шатанд тавих хяналтыг сайжруулж, хүнд суртал гаргахгүй ажиллах | зардлын "Нийтийн тээврийг хөгжүүлэх сан"-д 1,643,536.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.<br>13.3.2024 оны ногдол ашгийн мэдээлэл гараагүй байна.<br>13.4.Нийслэлээс баримталж байгаа бодлого, машин цагийн тарифт өөрчлөлт ороогүй бөгөөд ажилчдын цалин хөлсийг тус онд нэмэгдүүлээгүй байна.<br>13.5.Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2025 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж, санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь тайлагнах ажлыг зохион байгуулж ажилласан.<br>13.6.Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн дагуу 2025 оны төлөвлөгөөг батлуулж нийт 12 ажилтан албан хаагчдад тэтгэмж олгож, 220 ахмадуудад хүндэтгэл үзүүлж, 390 хүүхдэд гарын бэлэг гардуулсан байна.<br>13.7.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын 2025 оны төлөвлөгөөг батлан төлөвлөгөөнд "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд" болон "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлийн хүрээнд" гэх 2 чиглэлийг хамааруулан тайланг хагас, бүтэн жилээр тайлагнахаар баталсан.<br>Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг сурталчлан таниулах, хууль эрх зүйн мэдээллийг нийтийн тээврийн автобусны жолооч нарт таниулах ажлыг Тээврийн цагдаагийн алба, СХД-ийн Замын цагдаагийн алба, Нийтийн тээврийн бодлогын газартай хамтран тогтмол зохион байгуулж байна. Нийтийн тээврийн автобусны жолооч нарыг хамруулсан сургалтын үр дүнд Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийг мөрдөх,<br>Зөрчлийн тухай хуульд хариуцлага ногдуулахаар заасныг буруутай үйлдэл, эс үйлдэхүйгээр зөрчихгүй байх талаарх ойлголтыг аваад байна. Одоогийн байдлаар нийт 106 зам тээврийн осол, зөрчил гарснаас манай жолоочийн буруутай 76 осол зөрчил бүртгэгдсэн байна. | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | 13.11.Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газартай байгуулсан ажил үйлчилгээний гэрээ, санхүүжилтийн гэрээ байгуулан ажиллах, хэрэгжилтийг хангах<br>13.12.Батлагдсан цаг графикийн дагуу нийтийн тээврийн шугамын үйлчилгээний өглөөний эх авалт, оройн буултыг бүрэн биелүүлж ажиллах<br>13.13.Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж, Нийслэлийн<br>13.14.Тээврийн хэрэгслийн улсын үзлэг оношилгоонд орж тэнцсэн нийтийн тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлэх<br>13.15.Нийтийн тээврийн шугамын үйлчилгээний цаг, рейсийн алдагдалгүй ажиллах<br>13.16.Нийтийн тээврийн автобусны жолоочоос шалтгаалсан ашиглалтын саатлын цагийг бууруулах<br>13.17.Нийт хөдлөх бүрэлдэхүүнийг хавар, намрын техникийн улсын үзлэг оношилгоонд жилд хамруулах<br>13.18.Нийтийн тээврийн хэрэгслийг чиглэлийн хаяг, рейс цагийн графикаар бүрэн хангаж, шугамын үйлчилгээнд гаргах<br>13.19.Нийтийн тээврийн автобусны жолооч нарыг стандарт шаардлагын дагуу ажлын хувцсаар хангаж, шугамын үйлчилгээнд тогтмол өмсүүлж хэвшүүлэх<br>13.20.Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ 1,2-ыг батлагдсан хуваарийн дагуу тогтмол хийж гүйцэтгэх<br>13.21.Нийтийн зорчигч тээврийн хэрэгслүүдэд улирлын засвар үйлчилгээ хийх нэгдсэн график төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, ашиглалтад хяналт тавих | 13.8.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангаж ажиллаж байна.Нийт ажилтны 21 хувийг эмэгтэй ажилтнууд эзэлж байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үйлдвэрлэлийн осол бүртгэгдээгүй байна.<br>13.9.Хууль тогтоомж, стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж хэлтсийн 2025 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>13.10.Хөрөнгө оруулалтын ажилд Нийслэлийн хөрөнгө оруулалтын газартай хамтран захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. II ээлжийн барилгын ажлыг гүйцэтгэх 3 байгууллагын гэрээг цуцалсан бөгөөд НХОГ-аас ажлын тоо хэмжээг салгаж дахин төсөв гаргах ажил хийгдэж байна.<br>13.11.Нийтийн тээврийн бодлогын газартай 2025 оны 3 дугаар сарын 19 өдөр 2025-2030 он хүртэл хамтран ажиллах гэрээ хийсэн.<br>13.12.Өглөөний эх авалт болон оройн буултын зөрчил: Цагаасаа өмнө болон хоцорсон зөрчлүүдийг цаг тухайд нь Тээвэрлэлт үйлчилгээний хэлтсийн Хэсгийн дарга нар болон Тээвэр хөдөлгөөн зохицуулагч шууд илрүүлж мэдээлэл өгч, жолооч нарт хэсэг тус бүрээр болон нэгдсэн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан.<br>Мөн төхөөрөмжөөс шалтгаалсан Эх авалт, буултын зөрчлийг тухай бүрд "Улаанбаатар Смарт Карт" ХХК-ны<br>11315004 дугаарт холбогдож алдагдсан цагийг нөхөж авахаар, техникийн саатлаас шалтгаалсан зөрчилд тээврийн хэрэгслийн<br>бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор урсгал засвар, Техникийн Үйлчилгээ-1, Техникийн Үйлчилгээ-2-ыг хуваарийн дагуу тогтмол хийж гүйцэтгэж, нөөц тэрэг бэлдэн, бэлэн байдлыг хангаж тус тус арга хэмжээг авч байна.<br>13.13.Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулаагүй болно.<br>13.14.Нийт 150 автобус үзлэг оношлогоонд тэнцсэн дүгнэлттэй ажилд гарч байгаа.<br>13.15.Нийтийн тээврийн шугам цагийн 50732:16:00 даалгавар гүйцэтгэхээс 50044:12:00 цаг буюу 98.6%, рейс 45366.2 даалгавар гүйцэтгэхээс 34672.7 цаг буюу 76.3%-гүйцэтгэсэн | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | 13.22.Тээврийн хэрэгслийн техникийн саатлыг бууруулан ажиллах<br>13.23.Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж буй тээврийн хэрэгслийн гадна өнгө үзэмжийг сайжруулах ажлыг тогтмол зохион байгуулах<br>13.24.2025-2026 оны Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гарган батлуулж, биелэлтийг холбогдох дээд газарт заасан хугацаанд хүргүүлж ажиллах<br>13.25.УИХ-ын тогтоол, УИХ-ын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ЗГ-ын тогтоол, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл,<br>Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, НЗД-ын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах<br>13.26.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас "Бүтээн байгуулалтын жил"-ийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг өөрийн байгууллагын хүрээнд уялдуулан зохион байгуулж хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, тайлан мэдээг тогтоосон хугацаанд НЗДТГ-т хүргүүлж ажиллах<br>13.27.Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг байгуулан "Гамшгийн үед байгууллагад авах арга хэмжээний төлөвлөгөө" боловсруулж, хэрэгжүүлэн ажиллах<br>13.28.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд тавих, үзлэг шалгалт хийх, болзошгүй үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, ажлыг зохион байгуулах<br>13.29.Ажилчдыг нэг бүрийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангах | байна.<br>13.16.Ашиглалтын саатал:<br>➢ Жолоочоос шалтгаалсан ашиглалтын саатал<br>➢ Дугуй хагарч зогссон ашиглалтын саатал<br>➢ Чиглэл буруу сонгосон ашиглалтын саатал<br>➢ Зам тээврийн осол зөрчлөөс хамаарсан<br>➢ Угаалга цэвэрлэгээ<br>➢ Оношлогоо<br>➢ Зохицуулалт<br>гэсэн шалтгаанаар ашиглалтын саатал гарч байна. Нийт 2345:00 цагийн саатал гарсан байна.<br>13.17.2025 оны Хаврын улсын үзлэг оношилгоонд нийт 118 автобус орж тэнцсэн.<br>13.18.Шугам замд үйлчилж байгаа тээврийн хэрэгслийн Ютонг Евро V -32, Xiamen.Евро V – 100, дунд оврын каунти -17, Skybel цахилгаан- 1 автобусны лед хаягийг бүрэн шинэчлэн ажилд оруулж, санамж, лого,<br>гарааш дугаарыг шинэчлэн үйлчилгээнд гаргаад байна.<br>13.19.Жолооч нарт зуны улиралд өмсөх хантаазаар, өвлийн улиралд өмсөх поло цамцаар хангадаг бөгөөд шинэ жолооч нарыг хөдөлмөрийн гэрээ байгуулснаас хойш ажлын хувцсаар хангаж ажиллаж байна.<br>13.20.Батлагдсан хуваарийн дагуу сар бүр ТҮ:1-т 74-75, ТҮ:2-т 75-76 автобусыг үйлчилгээнд оруулсан. Нийт давхардсан тоогоор ТҮ:1-т 1450, ТҮ:2-т 1560 автобусанд техникийн үйлчилгээ хийгээд байна.<br>13.21.205 автобусанд явах эд ангийн засвар, (амартизатор болон втулка, пальц солих) заалны дулаацуулах системийн засварт давхардсан тоогоор 354 автобус, хийн компрессор буюу автоматын хуудсан клапанг цэвэрлэхэд<br>давхардсан тоогоор 100 автобус, тунадас хатаагчийн шүүр солиход давхардсан тоогоор 100 автобусанд тус тус засвар үйлчилгээ хийсэн.<br>13.22.Тээврийн хэрэгслийн техникийн саатлыг хагас жилийн байдлаар 513 цаг болж буурсан үзүүлэлттэй байна.<br>13.23.2025 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор нийт 212 тээврийн хэрэгсэл хамрагдсан байна.<br>13.24.Төлөвлөгөө гарган баталгаажуулж, сар бүрийн 25-нд | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | 13.30.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор хугацаат үзлэгт хамруулах<br>13.31.Нээлттэй ажлын байрны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, вэб сайтад зарлаж, сонгон шалгаруулалтыг хийж, байгууллагын хүний нөөцийн бодлогыг барьж ажиллах<br>13.32.Хэлтэс, нэгж, ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн тайланд хяналт тавьж, байгууллагын гүйцэтгэлийн тайланг дүгнэж ажиллах<br>13.33.Албан хэрэг хөтлөлт, архивын ажлыг зохих дүрэм, журмын дагуу явуулж, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гаргаж ажиллах<br>13.34.Байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлтийг хийж ажиллах<br>13.35. Хариутай албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж, тайланг гаргах<br>13.36.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журмыг тухай бүр шинэчлэх<br>13.37.Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд үндэслэлтэй шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллах<br>13.38.Тогтоосон хууль тогтоомжийн дагуу байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хугацаанд нь хийж, ашиглалтын хугацаа дууссан, үлдэх өртөггүй, шаардлага хангахгүй болсон тавилга эд хогшлыг актлуулах, саналыг НӨАУГ-т хүргүүлэн, шийдвэрлүүлэх<br>13.39.Худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу цахим хэлбэрээр явуулж, иргэд, олон нийтийн оролцоо, ил | Нийтийн тээврийн бодлогын газарт биелэлтийг тайлагнан хүргүүлж байна.<br>13.25.Нийслэлийн Засаг даргын захирамж, Албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл-13, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол-5 ирсний биелэлтийг хангаж ажллаж байна.<br>13.26."Бүтээн байгуулалтын жил"-ийн хүрээнд төлөвлөгөө боловсуулан ажиллаж байна. Нийт 16 ажил хийхээр төлөвлөснөөс 8 ажлыг хийж гүйцэтгээд байна.<br>13.27.Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг байгуулж "Гамшгийн үед байгууллагад авах арга хэмжээний төлөвлөгөө" боловсруулж Сонгино Хайрхан дүүргийн онцгой байдлын газарт хянуулж батлуулсан.<br>13.28.2025 оны 05 дугаар сарын 07,08-ны өдрүүдэд "Гал түймэр унтраах тактикийн дадлага, сургалтыг нийт ажилчдын дунд зохион байгуулсан.<br>13.29.Ажилчдын зуны хувцас худалдан авах тендер зарлагдсан хуулийн хугацаа хүлээгдэж байна.<br>13.30.3 дугаар улиралд эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах тендер 06 дугаар сарын 27-нд зарлахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.<br>13.31.Нээлттэй ажлын байрны зарыг FM 98,5 болон шуурхай зар сонингоор дамжуулан зарлаж, сонгон шалгаруулалтыг хийж байна.<br>13.32.ДХШХ-ээс Удирдамжтай шалгалт 01-ийн хүрээнд 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс 17-ны хооронд Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс, 02-ын хүрээнд 06 дугаар сарын 09-ний өдрөөс 16-ны өдрүүдэд Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсийн ажилчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт шалгалт хийж ажилласан. Хэлтсүүдийн гүйцэтгэлийн тайланг дүгнэх хугацаа болоогүй байна<br>13.33.Албан хэрэг хөтлөлт, архивын ажлыг зохих дүрэм, журмын дагуу явуулж байна. Өргөдөл, гомдлын тайлан мэдээг тогтоосон хугацаанд холбогдох газарт хүргүүлэн ажиллана<br>13.34.Байгууллагад 2024 онд үүсэж хөтлөгдсөн баримт бичгүүдийг холбогдох хэлтэс, ажилтнуудаас хүлээн авч байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлтийг хийж ажилласан.<br>13.35.Хариутай албан бичиг 71 ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж, тайлан гаргаж холбогдох албан тушаалтанд танилцуулсан | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулах<br>13.40.Хууль тогтоомжийн биелэлтэд хяналт, тавьж, эрсдэлийн удирдлагаар хангах<br>13.41.Тээврийн хэрэгслийн GPS-ийн хяналтын системийг хэрэгжүүлэх, тээврийн хэрэгслийн смартын тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах | 13.36.Цалин хөлсний журмыг шинэчлэн боловсруулсан. Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах шатандаа явж байна<br>13.37.Иргэдээс ирүүлсэн 170 өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд үндэслэлтэй шийдвэрлэж, хариуг албан ёсоор өгч хэвшээд байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног, 20 цаг, 0 минут байна. Зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, чиглэлээр арга хэмжээ авч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна<br>13.38.2024 оны жилийн эцсийн тооллогын ажлыг хийж гүйцэтгэж үр дүнг тайлагнасан. Газрын даргын А/38 дугаар тушаалаар 2025 оны эд хөрөнгийн хагас жилийн тооллого хийх ажлын хэсэг байгуулагдсан.<br>13.39.2025 оны худалдан авах төлөвлөгөөнд 34 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс 17 төсөл арга хэмжээг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулсан. 14 төсөл арга хэмжээг Tender.gov.mn сайтад нийтэлж 9 гэрээ байгуулж үр дүнг нийтэлсэн. 5 арга хэмжээ нь үнэлгээний болон гэрээ хийх явцтай байна. Дээрх мэдээллийг шилэн данс болон төрийн худалдан авахын цахим<br>системд нийтэд мэдээлсэн болно.<br>13.40.2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан Удирдамжтай шалгалт-01-ийн хүрээнд байгууллагын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байгаа хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлгээ хийж ажилласан.<br>• 2025 оны байдлаар байгууллагын хэмжээнд 9 хууль тогтоомжийг хэрэгжүүлж байна.<br>• Байгууллагын хэмжээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн тайлан гаргахдаа бүрэн хэрэгжсэн 5 ажлыг дутуу тайлагнасан зөрчлийг арилгуулж ажилласан.<br>13.41.Тээврийн хэрэгслийн смартын тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах зорилгоор жолооч болон шалгах механик оройн буулт өглөө эх авалтын өмнө төхөөрөмжийн хэвийн ажиллагааг шалгаж байна. Тээврийн хэрэгслийн GPS-ийн хяналтын системийг тээвэр хөдөлгөөн зохицуулагч нар өглөөний 05:30 минутаас оройны 00:00 хүртэл хяналт тавин ажиллаж байна. | | |
| | Зорилт 14.Дүрмээр хүлээсэн чиг үүргийг | 14.1.Нийтийн тээврийн үйлчилгээний стандартыг мөрдөж, үйлчилгээний ёс зүйн хэм, хэмжээ, хууль тогтоомж, дүрэм, | 14.1.Нийтийн тээврийн үйлчилгээний стандартыг мөрдөж, үйлчилгээний ёс зүйн талаарх дүрэм, журмыг баримтлан ажиллаж байна. | 100% | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 9 | хэрэгжүүлэх зорилт:Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 28 дугаар тогтоол | журмыг чанд баримтлан үйл ажиллагааны хувьд ашигтай ажиллана. | | | |
| Нийт үнэлгээ | | | | 80,46% | 80,46% |

**Дөрөв: Дүгнэлт**

2024 онд үйлдвэрийн газрын үйл ажиллагааны хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тайлангийн маягтад өгөгдсөн бүлгийн дагуу тус бүр үнэлж, нэгтгэн дүгнэсэн.

1.Стратеги төлөвлөгөөний зорилго-1:Нийтийн тээвэр, логистик: Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан 3 ажлыг тайлагнасан нь **93% буюу тодорхой үр дүнд хүрсэн**.

2.Стратеги төлөвлөгөөний зорилго-2:НХТЖҮЧ-5.3.2, 5.1.Цахим засаглал:Иргэдийн оролцоог хангасан, авилгаас ангид, үр нөлөөтэй, цахимжсан, хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалыг төлөвшүүлнэ.: арга хэмжээний хүрээнд 1 хэрэгжсэн ажлыг тайлагнаж, биелэлтийг **100% буюу бүрэн хэрэгжсэн.**

3.Стратеги төлөвлөгөөний зорилго-3:НХТЖҮЧ-5.1.2, НХТ-5.2.Орон нутгийн засаглалын бие даасан байдал: Төрийн үйлчилгээний ил тод байдал нэмэгдэнэ: Арга хэмжээний хүрээнд 1 ажил зохион байгуулж тайлагнаж **50% буюу судалгааны түвшинд.**

4.Стратеги төлөвлөгөөний зорилго-4:НХТЖҮЧ-5.1.2, НХТ-5.2.Орон нутгийн засаглалын бие даасан байдал:Төрийн үйлчилгээний ил тод байдал нэмэгдэнэ: Арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан 6 ажлыг тайлагнаж **81,25% буюу тодорхой үр дүнд хүрсэн.**

5.Стратеги төлөвлөгөөний зорилго-5:НЗДҮАХ-4.2.3, ХАХТ 4.2.3.1, НХТЖҮЧ 4.6.1, НХТ-5.2.Орон нутгийн засаглалын бие даасан байдал:Төрийн үйлчилгээний ил тод байдал нэмэгдэнэ: Арга хэмжээний хүрээнд 3 зохион байгуулсан ажлыг тайлагнаж **84% буюу тодорхой үр дүнд хүрсэн.**

6.Стратеги төлөвлөгөөний зорилго-6:НХТЖҮЧ 5.3.2.5, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоол НХТ-5.2.Орон нутгийн засаглалын бие даасан байдал:Төрийн үйлчилгээний ил тод байдал нэмэгдэнэ: Ажлын хүрээнд 3 ажлыг зохион байгуулж тайлагнасан ба **81.6% буюу тодорхой үр дүнд хүрсэн.**

7.Стратеги төлөвлөгөөний зорилго-7:НХТЖҮЧ 5.1.1, НХТ-5.3.Ил тод байдал, хяналт:Нийслэл дэх төрийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, хяналт шалгалтын ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ: Арга хэмжээний хүрээнд 9 ажлыг зохион багуулж тайлагнасан **51,11% буюу хэрэгжих түвшинд.**

8. Зорилго 13.Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилго: Арга хэмжээний хүрээнд 41 аэлыг хэрэгжүүлж тайлагнасан ба **82,94% буюу тодорхой үр дүнд хүрсэн.**

9. Зорилт 14.Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт:Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 28 дугаар тогтоол: Арга хэмжээний хүрээнд 1 ажлыг хэрэгжүүлж **100% буюу бүрэн хэрэгжсэн.**

"ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ" ОНӨААТҮГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 65 арга хэмжээ төлөвлөж, төлөвлөсөн ажлын хүрээнд бүрэн тайлагнаж ажилласан. 2025 оны хагас жилийн үйл ажиллагааг 80,46% буюу хэрэгжих шатанд явж байна гэж үнэлэв.

Тав: **Цаашид анхаарах асуудал:**

1. Хэрэгжих шатанд явж байгаа арга хэмжээнүүдийг эрчимжүүлж ажиллах.
2. Тайланд тоо үзүүлэлт, статистик мэдээлэл, харьцуулалтыг түлхүү ашиглах.

ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ АЖИЛТАН С.АДЪЯАСҮРЭН

ДҮГНЭЛТ БИЧСЭН:
ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ХЯНАЛТЫН АЖИЛТАН Б.ЦЭНД-АЮУШ